



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/454

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1а, 29.2, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Аймгийн 2018 оны төсвийн төсөл, 2019, 2020 оны төсвийн төсөөлөл, хагас жилийн санхүүгийн тайланг Сангийн яаманд хянуулж батлуулах болон 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын зураг төсвийг холбогдох яамдуудад хүргэх, төсөвт тусгуулж оруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах 3500000 /Гурван сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ